# ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

*Ч.Энхбаатар.Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн ахмад*

**Хураангуй:** Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг Мөрдөн шалгах ажиллагааг шуурхай, шударга, хуульд нийцүүлэн явуулах, үйлдэгдсэн гэмт хэргийг богино хугацаанд бодитойгоор илрүүлж, хуулийн хүрээнд хэрхэн шийдвэрлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зорьсон.

**Abstract:** Summary: The Criminal Procedure Code is designed to ensure prompt and fair investigations of crimes against the law, to ensure that the crimes committed in a timely manner will be realized in a timely manner and how to manage the legal framework.

**Түлхүүр үг:** мөрдөн шалгах ажиллагаа, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, удирдлага зохион байгуулалт.

**Key word:** Investigation, Crimes against ownership right, Management Organization.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт ярихын өмнө Мөрдөн шалгах ажиллагааны талаар дурьдах нь зүйтэй байх. Мөрдөн шалгах ажиллагаа бол үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн илрүүлэх зорилготой, ээдрээ төвөгтэй, хойшлуулашгүй шуурхай ажиллагаа шаардсан, танин мэдэхүйгээс таньж мэдэхэд чиглэгдсэн, төрийн эрх бүхий байгууллагаас зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрхлэн хэрэгжүүлдэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хамгийн гол хэсэг бөгөөд уг ажиллагааг шуурхай, шударга, хуульд нийцүүлэн явуулснаар үйлдэгдсэн гэмт хэргийг богино хугацаанд бодитойгоор илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцлийг бүрдүүлдэг онцгой ажиллагаа юм[1].

[1] Ё.Сагсай. Мөрдөн байцаах ажлын чанар үр дүнг тодорхойлоход прокурорын хяналтын гүйцэтгэх үүрэг, үр нөлөө. УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгуулагдсаны 10 жилийн ойд зориулсан ЭШХ-ийн хурлын илтгэл.

Мөрдөн шалгах ажиллагааны удирдлагыг бүх шатанд амжилттай хэрэгжүүлэхэд хэд хэдэн хүчин зүйл бодитоор нөлөөлж байгаа бөгөөд түүнийг нэгтгэн дүгнэвэл дараах зөрчил, мөрдөн байцаах албаны аль ч шатны нэгжид өнөөдрийг хүртэл оршсоор байна. Үүнд:

- Мөрдөгчийн ажлын дадлага, туршлага, мэдлэг,ур чадвар сул, шаардлагын хэмжээнд хүрч ажиллахгүй байгаа[1]
- Мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөн байцаах албаны даргын дэмжлэг туслалцаа бага, зарим тохиолдолд цаг үедээ хэрэгждэггүй, оновчтой бус байснаас үйл ажиллагааны хүссэн үр дүнд бодитоор нөлөөлж алдаа, дутагдал гардаг;
- Мөрдөн байцаах албаны нэгжийн удирдлагын үйл ажиллагааны уялдаа холбоо, бүтэц, зохион байгуулалт боловсронгуй бус, байнга өөрчлөгдөж, шинэчлэгдэж байгаа нь тогтвортой бус байдлыг бий болгодог;
- Мөрдөгчийн ажлын гүйцэтгэлийн үнэлэмж харилцан адилгүй, уян хатан хандах боломж багатай, тоон үзүүлэлтээр дүгнэдэг;
- Үйл ажиллагааны шуурхай, соёлч байдал дутмаг, мөрдөгчийн ёс зүй, зан харилцаа, ажлын хандлага зарим талаараа доголдолтой зэрэг гадаад, дотоод орчны олон хүчин зүйлээс шалтгаалж байна.

Энэхүү зөрчил дутагдал гарах үндсэн шалтгааны нэг мөрдөгчийн үйл ажиллагааг зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах ажил сул, цаг үедээ хэрэгжихгүй байгаатай шууд холбоотой бөгөөд цаашид түүнийг сайжруулах, орчин үеийн менежментийн удирдлагатай хослуулан нь зүй ёсоор тавигдаж байгааг харуулж байгаа хэрэг юм.

Удирдах үйл явц нь өөр хоорондоо харилцан уялдаа бүхий төлөвлөлт, зохион байгуулалт, идэвхжүүлэлт, хяналт гэсэн удирдлагын чиг үүргээс бүрддэг гэж онолын түвшинд үздэг.

[1] Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтооход чиглэсэн мөрдөн шалгах ажиллагаа өнөөдөр гол төлөв байцаалтын арга, тактик түшиглэсэн нотлох ажиллагаа явагдаж байгаа нь шинжпэх ухаан, техник, технологи, инновацийн хөгжлийн орчин цаг үеэс ихээхэн хоцорч байна. Энэ нь өөрөө мөрдөн шалгах ажиллагаанд шинэчлэлийг шаардаж байна.

Менежментийн удирдлагын чиг үүргийг мөрдөн шалгах ажиллагааны хэрэгжүүлж буй чиг үүрэгтэй уялдуулан тайлбарлахыг зорив.

a. Төлөвлөх;
b. Зохион байгуулах;
c. Мотиваци буюу идэвхжүүлэх;
d. Хянах;

**Төлөвлөлт** гэдэг нь байгууллагын үйл ажиллагааг төлөвлөнө гэсэн үг юм. Үүнийг мөрдөн шалгах ажиллагаатай холбон авч үзвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино"[1]гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажиллагаа гэж үзэж болох юм.Өөрөөр хэлбэл мөрдөн шалгах ажиллагааны дэвшүүлсэн зорилго, зорилтод хүрэхийнтулд олон янзийн арга, таамаглалаас хамгийн зөв, оновчтой үр дүнтэй гэсэн арга тактикыг сонгож, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, төлөвлөх үйл явц бөгөөд мөрдөн шалгахажиллагааны төлөвлөлтийг дэвшүүлж буй зорилго, цаг хугацаа, цар хүрээ, хэрэгжүүлэх субьект зэргээс шалтгаалан менежментийн онолын төлөвлөлтийн 3 үндсэн түвшинд ангилж үзэх шаардлагатай.

1. Дээд буюу стратегийн
2. Дунд буюу тактикийн
3. Доод буюу үйл ажиллагааны.

**Зохион байгуулалт** гэдэг нь мөрдөн шалгах ажиллагааны тодорхой түвшингийн зорилго, зорилтод хүрэхийн тулд төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй зохион байгуулалтын ажиллагаанд үүнд удирдлагын үүрэг оролцоо маш чухал бөгөөд бүх шатны менежерийн зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагын арга барилыг хослуулан хэрэгжүүлэх шаардлагатай гардаг. Өөрөөр хэлбэл стратеги, тактик, үйл ажиллагааны түвшинд зохион

[1] Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл. Уб., 2017. №23

байгуулах, хэрэгжүүлэх арга, тактик, дэвшүүлэх санаа, ажиллах (нөөц буюу орц) хүн хүч, ашиглах (капетал буюу тоног төхөөрөмж, техник хэрэгсэл) эдийн засаг, санхүүгийн хувиарлалтүйл ажиллагаандаа оновчтойгоор нэгтгэн зангидах ашиглах тухайн шатны менежерийн ур чадвар,эрх мэдлийн хэмжээ хязгаарын тусламжтайгаар байгууллагын янз бүрийн хэсгийн үйл ажиллагааг хооронд нь холбодог.

Менежерүүд нь ажиллах хүч, цаг хугацаа, хөрөнгө мөнгө, тоног төхөөрөмж, түүхий эд материал зэрэг олон төрлийн нөөцүүдтэй цаг үргэлж харьцан ажиллаж байдаг. Зохион байгуулалт нь зөв оновчтой хэрэгжүүлснээр зорилгодоо хүрэх боломж бүрдэх боловч үйл ажиллагаанд нь гадаад болон дотоод орчны нөлөөлөл байдгийг тооцох шаардлагатай. Иймээс хууль эрх зүйн орчин, төсөв санхүүгийн эрх мэдэл зэрэг шаардлагатай менежерийн үйл ажиллагааны хариуцлага, бүрэн эрхийг тодорхойлох, мэдээллийн урсгал болон эрх мэдлийн хэмжээ хязгаарыг тодорхойлох шаардлага тавигддаг.

**Мотиваци** гэдэг нь онолын хувьд хүний хэрэгцээг хангах замаар байгууллага зорилгодоо хүрэх арга зам гэж үздэг бол мөрдөн шалгах ажиллагааны удирдлагын үйл ажиллагаатай холбон тайлбарлавал мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгч субьектүүдтэй ажиллах идэвхижүүлэх удирдлагын төрөл бүрийн арга, ажиллагааг ашиглан ухамсарлуулах, урамшуулах, зоригжуулах, хариуцлагжуулах зэрэг ухамсарт харилцааны сонгомол боломж гэж ойлгож болох бөгөөд энэ нь эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажсан, эрх олгогдсон байх шаардлага тавигдана.

**Хяналт** гэдэг нь өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд зөв оночтой арга замыг сонгож түүнийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаандаа нийцүүлэн зохион байгуулалтын хамгийн оновчтой хэлбэрээр явуулж буй арга ажиллагааны үр дүнг тооцох хяналтын систэм гэж үзэж болох бөгөөд явцын гүйцэтгэл, түүнээс гарах эрсдлийг тооцох, учирч болох хор уршгийг арилгах, нөөц, гарцыг зөв хувиарлах зэргээр буруу үйлдлийг зогсоох, урьдчилан сэргийлэх үр дүнг тооцох, тодорхойлох үйл ажиллагаа юм.

Мөрдөн шалгах ажиллагаанд менежментийн удирдлагын чиг үүрэг нь мөрдөн байцаах албанаас зорилго, зорилтод хүрэх алс хэтийн стратеги төлөвлөгөөнөөс эхлээд тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, нотлох үйл ажиллагааг явуулахдаа хэргийн шалгах болон түүвэр төлөвлөгөөг гаргаж байгаа нь төлөвлөлтийн үйл ажиллагаа бол зохион байгуулалтын ажиллагаа нь батлагдсан төлөвлөгөөний дагуу мөрдөн шалгах ажлын ач холбогдлыг эрэмбэлэн тодорхой порцессийн ажиллагаа явуулах зардал, өртөгийг тооцох, календарчилан төлөвлөгөөний дагуу байцаалт, мэдүүлэг, үзлэг, туршилт хийх гэх мэт олон төрөлт арга, ажиллагааг ойлгоно. Харин мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй байгууллага, албан тушаалтан удирдан зохион байгуулж буй удирдлага болон мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгч субьектүүдийг урамшуулах, идэвхижүүлэх түүнээс гарах үр дүнг тооцох дүгнэх нь хянах порцесс бөгөөд эдгээр үйл ажиллагааг бүхэлд нь **“мөрдөн шалгах ажиллагааны менежментийн удирдлага”-ын** чиг үүргийн хэрэгжилтийн цогц ойлголт гэж тодорхойлж болох юм.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй мөрдөгчийн үйл ажиллагааг менежментийн чиг үүрэгтэй уялдуулан мөрдөгчийн үйл ажиллагааны төлөвлөлт нь ЭХХШ тухай хуулийн зорилтыг хэрэгжүүлэхээр гаргаж буй тухайн гэмт хэргийг шалгахаар гаргасан түүвэр төлөвлөгөө гэж үзээд зохион байгуулалтын үйл ажиллагаа нь таамаглал, төлөвлөгөөний дагуу гарсан дэс дараалалтай, ач холбогдлоор нь эрэмбэлсэн ажлыг календарчилааар гүйцэтгэхээр хэрэгжүүлэх үйл явц бол мотиваци, хяналтын порцесс нь мөрдөн шалгах ажиллагааг удирдагч болох менежерээс мөрдөгчийн үйлдлийг идвэхижүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг тооцох, урамшуулах, хариуцлагажуулах зэргээр тогтоосон эрх зүйн хэм хэмжээнд үндэслэн удирдлагаас сонгон хэрэгжүүлэх боломжит харилцааны хандлага, ур чадварын шалгуур илэрхийлэл гэж ойлгож болох бөгөөд эндээс үзэхэд орчин үеийн **“Мөрдөгч** менежмент”-ийн дүр төрөхийг бий болгох боломжтой гэж үзэж байна

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг нь 2015 оны Монгол Улсын Эрүүгийн хууль /Шинэчлэн найруулсан/-ийн 17 дугаар бүлэгт
17.1 дүгээр зүйл Хулгайлах,
17.2 дугаар зүйл Дээрэмдэх,

17.3 дугаар зүйл Залилах,
17.4 дүгээр зүйл Хөрөнгө завших,
17.5 дугаар зүйл Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших,
17.6 дугаар зүйл.Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх,
17.7 дугаар зүйл.Автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах,
17.8 дугаар зүйл.Эд хөрөнгө устгах, гэмтээх,
17.9 дүгээр зүйл.Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах,
17.10 дугаар зүйл.Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих,
17.11 дүгээр зүйл.Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх,
17.12 дугаар зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгт гэмт хэргүүд хамрагдаж байна.

Дээрхи гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагааны удирдлага зохион байгуулалтын чиглэлээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд[1] **Мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын эрх хэмжээг зааж өгсөн үүнд:**

1.Мөр дөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад дараах эрхтэй. Үүнд:

- > Мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шуурхай зохицуулалт хийх;
- > Мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн мөрдөгчид даалгах;
- > Шаардлагатай гэж үзвэл тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорт мэдэгдэж хэргийг нэг мөрдөгчөөс нөгөө мөрдөгчид шилжүүлэх;
- > Хавтаст хэргийн материалтай биечлэн танилцах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, мөрдөгчид дэмжлэг үзүүлэх зорилгоор бичгээр зааварчилга өгч, биелэлтийг хангуулах;

[1] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль Уб. 2017. 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг

> Шаардлагатай тохиолдолд мөрдөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч хууль зөрчиж оролцогчид хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах[1].

Дан ганц эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиас гадна мэргэжлийн удирдлагаар хангах нь учир дутагдалтай тул эхлээд эдгээр гэмт хэргүүдийг тайлбарлаж мэргэжлийн удирдлагаар хангах нь зүйтэй гэж үзэж байна. Тухайлбал:

**Хулгайлах гэмт хэрэг:** Энэ бол бидний хамгийн сайн мэдэх хэрэг, мэдэхээс ч зайшгүй энэ хэрэг маань 2015 онд батлагдсан хувилбараараа бол бусдын эд хөрөнгийг хууль бусаар авч байгаа үйлдэл бол хулгайлах гэмт хэрэг гээд материалаг бус шинжтэй заагаад өгчихсөн байсан харин 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулж уг хуулийн тайлбарт /Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй/ гэж заасан нь 17.1-д 300 нэгж буюу 300,000 төгрөг хохирол шаардаж байгаа харин 17.2, 17.3-д 300,000 төгрөг хохирол шаардахгүй хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч орсон л бол гэмт хэрэгт тооцогдохоор болж бүлэглэн давтан, байнга, булаах уулгалан довтлох гэмт хэрэг үйлдсэн бол хүндрүүлэн үздэг байсныг хассан байгаа. Ноцтой хохирол гэдэг бол амьдралын эх үүсвэрээс нь салгах гэдгийг ойлгож байна.

Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ[2].

2.Энэ гэмт хэргийг:

[1] Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл. Уб.,2017. №23
[2] Монгол Улсын Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. Уб., 2015. №06

2.1. хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч;

2.2. түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж;

2.3. ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;

2.4. учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;

3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.

**Дээрэмдэх гэмт хэрэг:** Энэ хуульд булаах гэмт хэрэг байхгүй болсон. Өмнө нь бид хүч хэрэглэсэн, хэрэглээгүй, амь биед аюултай, аюулгүй, дээрэмдэх гэмт хэрэг, булаах гэмт хэрэг гээд маргаад байдаг байсан. Шинэ хуулиар хүч хэрэглэсэн, хэрэглээгүй дээрэмдэх гэмт хэрэг байхаар хуульчилж харин хүч хэрэглэсэн бол хүндүүлэх шинжээр зүйлчилэхээр зохицуулсан.

1 .Бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2 .Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж авахаар довтолсон бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;

3.2.зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн;

3.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж хуульчилсан.

**Дүгнэлт.** Энэхүү үүссэн нөхцөл байдлаас үзэхэд мөрдөн шалгах ажиллагааны удирдлагад тулгамдаж буй асуудлыг тал бүрээс нь шинжлэх ухааны үндэстэй, бодитой судлан тогтоох, улмаар түүнийг сайжруулахад чиглэсэн тодорхой үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх шаардлага бий болсныг илтгэн харуулж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны удирдлагыг орчин цагийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгон, гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд бодит байдлаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх, улмаар эрх зүйн болон зохион байгуулалтын орчин нөхцлийг сайжруулан шинэ шатанд гаргаснаар мөрдөн шалгах ажиллагаанд хууль ёс, хүний эрх, чөлөө тууштай хангагдах нөхцөл боломж бүрдэнэ гэж дүгнэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Ё.Сагсай. Мөрдөн байцаах ажлын чанар үр дүнг тодорхойлоход прокурорын хяналтын гүйцэтгэх үүрэг, үр нөлөө. УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгуулагдсаны 10 жилийн ойд зориулсан ЭШХ-ийн хурлын илтгэл.
2. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. Уб., 2009. 634 дэх тал
3. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл. Уб., 2017. №23
4. Монгол Улсын Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. Уб., 2015. №06